



МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 03 сарын 31 өдөр

Дугаар A/90

Улаанбаатар хот

Г Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Далай ашиглах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хөлөг онгоцыг алсын зайнаас хянах үйл ажиллагааны журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (М.Энхболд)-т үүрэг болгосугай.



080000169

## ТАНИЛЦУУЛГА

Хөлөг онгоцыг алсын зайнаас  
хянах үйл ажиллагааны журам

Монгол Улс 1996 онд Олон Улсын Далайн Байгууллага /ОУДБ/-д гишүүнээр элссэн бөгөөд Далайд хүний аюулгүй байдлыг хангах тухай 1974 оны олон улсын конвенцод 2001 онд, Далайн Хиймэл Дагуулын Олон Улсын Байгууллагын 1979 оны конвенцод 2011 онд тус тус нэгдэн орсон.

Далайн Хиймэл Дагуулын Олон Улсын Байгууллагын 1979 оны конвенцын гол зорилго нь хөдөлгөөнт хиймэл дагуулын тусламжтайгаар сансрын технологийг ашиглан хөлөг онгоцыг алсын зайнаас илрүүлэх, хянах, ослын болон гамшгийн үед хүний аюулгүй байдлыг хангах, шаардлагатай нөхцөл байдал үүссэн тохиолдолд тэдэнд дэмжлэг үзүүлэх боломжийг нэмэгдүүлэх, хөлөг онгоцны багийн гишүүдтэй эргийн хяналтын холбоо барих, мэдээлэл солилцох боломжийг сайжруулахад чиглэгдсэн.

Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд нийт 495.060 тонны даац бүхий 24 орны 256 хөлөг онгоц өнөөдрийн байдлаар Монгол Улсын төрийн далбааг мандуулан их далайд аялж байна.

Далбааны эзэн улсын хувьд хөлөг онгоцны аюулгүй байдлыг хангах, хөлөг онгоцны байршил тогтоох, алсын зайнаас хяналтыг хэрэгжүүлэх нь Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг юм.

Мөн Олон Улсын Далайн Байгууллагаас Монгол Улсын далайн тээврийн салбарт хийсэн аудитын шалгалтын зөвлөмжөөр Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй хөлөг онгоцны аюулгүй байдлыг хангах, ослын болон гамшгийн үед хүний аюулгүй байдлыг хангах, байршил тогтоох, алсын зайнаас хяналт тавих шаардлагатайг онцолсон.

Иймд Далай ашиглах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-т "Хөлөг онгоцыг алсын зайнаас хянах үйл ажиллагааны журмыг далайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална" гэж заасны дагуу тус журмын төслийг боловсруулав.

- - - o O o - - -

## **ХӨЛӨГ ОНГОЦЫГ АЛСЫН ЗАЙНААС ХЯНАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРМЫН ТӨСӨЛД ХИЙСЭН НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ**

### **1. Журам батлуулах үндэслэл, шаардлага**

Монгол Улс 1996 онд Олон Улсын Далайн Байгууллага /ОУДБ/-д гишүүнээр элссэн бөгөөд Далайд хүний аюулгүй байдлыг хангах тухай 1974 оны олон улсын конвенцод 2001 онд, Далайн Хиймэл Дагуулын Олон Улсын Байгууллагын 1979 оны конвенцод 2011 онд тус тус нэгдэн орсон.

Далайн Хиймэл Дагуулын Олон Улсын Байгууллагын 1979 оны конвенцын гол зорилго нь хөдөлгөөнт хиймэл дагуулын тусламжтайгаар сансрын технологийг ашиглан хөлөг онгоцыг алсын зайнаас илрүүлэх, хянах, ослын болон гамшигийн үед хүний аюулгүй байдлыг хангах, шаардлагатай нөхцөл байдал үүссэн тохиолдолд тэдэнд дэмжлэг үзүүлэх боломжийг нэмэгдүүлэх, хөлөг онгоцны багийн гишүүдтэй эргийн хяналтын холбоо барих, мэдээлэл солилцох боломжийг сайжруулахад чиглэгдсэн.

Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд нийт 495.060 тонны даац бүхий 24 орны 256 хөлөг онгоц өнөөдрийн байдлаар Монгол Улсын төрийн далбааг мандуулан их далайд аялж байна.

Далбааны эзэн улсын хувьд хөлөг онгоцны аюулгүй байдлыг хангах, хөлөг онгоцны байршил тогтоох, алсын зайнаас хяналтыг хэрэгжүүлэх нь Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг юм.

Далай ашиглах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-т "Хөлөг онгоцыг алсын зайнаас хянах үйл ажиллагааны журмыг далайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална" гэж заасан.

### **2. Журмын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэгдсэн хөлөг онгоцны аюулгүй байдлыг хангах, далайн хүрээлэн буй орчныг хамгаалах, далбааны эзэн улсын хяналтыг хэрэгжүүлэх үүднээс хөлөг онгоцыг алсын зайнаас хянах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

Уг журмын төсөл нь 7 зүйл, 39 заалтаас бүрдэнэ.

Энэхүү журам нь Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэгдсэн олон улсын аялал хийж буй 300 тонн болон түүнээс дээш бохир даацтай ачаа тээврийн хөлөг онгоц, мөн өрөмдлөгийн цамхагт үйлчлэх бөгөөд бохир даац нь 300 тонноос бага даацтай, далайн эргээс 40 миль (74 км) хүртэлх зайд үйл ажиллагаа явуулж буй хөлөг онгоц, хөвөгч тавцанд хамаарахгүй.

### **3. Журмын төсөл батлагдсаны дараа хууль ёсны ашиг сонирхол нь аливаа байдлаар хөндөгдөж болохийц бүлгийг тодорхойлох**

Журмын төсөл батлагдсаны дараа далайн тээврийн үйл ажиллагаа эрхэлж буй хувь хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь ямар нэг байдлаар хөндөгдөхгүй.

**4. Хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэх**

Энэхүү журмын төсөлд хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад учруулсан, аливаа хүнд суртал, авлига үүсэх нөхцөл бүрдүүлсэн зохицуулалт агуулаагүй болно.

**5. Тухайн асуудлыг зохицуулж байгаа урьд нь батлагдсан шийдвэр байгаа эсэх, тушаалыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, санхүү эдийн засгийн тогтолцоо.**

Далайд хүний аюулгүй байдлыг хангах тухай 1974 оны олон улсын конвенц, Далайн Хиймэл Дагуулын Олон Улсын Байгууллагын конвенцыг олон улсын далайн тээвэрт оролцож буй хөлөг онгоц, далбааны эзэн улс, боомтын болон эргийн улс бүр даган мөрдөн, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Журмын төсөлд тусгагдсан харилцааг зохицуулсан эрх бүхий байгууллагаас баталсан эрх зүйн акт өмнө нь байгаагүй.

Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэгдсэн хөлөг онгоцуудыг алсын зайнаас хянах үйл ажиллагааг далбааны эзэн улсын зүгээс Далайн захиргааны Хөлөг онгоцны бүртгэл, хяналтын алба хэрэгжүүлэн ажилладаг. Иймд энэхүү журмыг хэрэгжүүлэхэд шинээр хүний нөөц шаардагдахгүй бөгөөд Далайн захиргааны одоогийн орон тоо, төсөвт багтаан хэрэгжүүлнэ.

Хөлөг онгоцны алсын зайн хяналтын үйл ажиллагааг хөдөлгөөнт хиймэл дагуулын тусламжтайгаар сансрын технологийг ашиглан хэрэгжүүлэхэд гарах зардлыг Далай ашиглах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.15-д “хөлөг онгоцны бүртгэлийн үйлчилгээний орлогын 20-иос доошгүй хувийг хууль тогтоомжийн хүрээнд далбааны эзэн улсын хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зориулан захирсан зарцуулах” гэж заасны дагуу хөлөг онгоцны бүртгэлийн орлогоос Далайн захиргааны үйл ажиллагааны орлого, зарлагын төлөвлөгөөнд жил бүр тусган санхүүжүүлэх бүрэн боломжтой.



Зам, тээврийн хөгжлийн сайдын  
20.23. оны 03 дугаар сарын 31-ны  
өдрийн 11:00 дугаар тушаалын хавсралт

9020050420 5919437 СБА7509

## ХӨЛӨГ ОНГОЦЫГ АЛСЫН ЗАЙНААС ХЯНАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэгдсэн хөлөг онгоцны аюулгүй байдлыг хангах, далайн хүрээлэн буй орчныг хамгаалах, далбааны эзэн улсын хяналтыг хэрэгжүүлэх үүднээс хөлөг онгоцыг алсын зайнаас хянах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Энэхүү журам нь Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэгдсэн олон улсын аялал хийж буй 300 тонн болон түүнээс дээш бохир даацтай ачаа тээврийн хөлөг онгоц, мөн өрөмдлөгийн цамхагт үйлчилнэ.

1.3. Бохир даац нь 300 тонноос бага даацтай, далайн эргээс 40 миль (74 км) хүртэлх зайд үйл ажиллагаа явуулж буй хөлөг онгоц, хөвөгч тавцанд энэ журам хамаарахгүй.

1.4. Далайн захиргаа нь (цаашид “Захиргаа” гэх) хөлөг онгоцыг алсын зайнаас хянах үйл ажиллагааг Олон Улсын Далайн Байгууллагаас хүлээн зөвшөөрсэн үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай (цаашид “үйлчилгээ үзүүлэгч” гэх) гэрээ байгуулсны үндсэн дээр хэрэгжүүлнэ.

1.5. Хөлөг онгоцыг алсын зайнаас хянах үйл ажиллагаандaa Олон Улсын Далайн Байгууллагаас баталсан Далайн тээврийн гамшигаас хамгаалах дэлхий нийтийн системийг (цаашид “систем” гэх) ашиглана.

### Хоёр. Хөлөг онгоцны байршил тогтоох төхөөрөмж

2.1. Хөлөг онгоц нь Далай ашиглах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-т заасан хөлөг онгоцыг алсын зайнаас хянах зориулалттай байршил тогтоох, харилцаа холбооны төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

2.2. Байршил тогтоох төхөөрөмж нь дараах шаардлагыг хангасан байна.

2.2.1. системийн төхөөрөмжтэй холбогдож 6 цагийн давтамжтайгаар автоматаар байршлын мэдээллийг дамжуулах,

2.2.2. мэдээлэл дамжуулах давтамжийг өөрчлөх боломжтой байх,

2.2.3. эрчим хүчний нөөц эх үүсвэртэй байх,

2.2.4. цахилгаан соронзон орны нэлөөнд автахгүй байхаар суурилуулагдсан байх.

### Гурав. Хөлөг онгоцны байршлын мэдээлэл дамжуулах

3.1. Далайд хүний аюулгүй байдлыг хангах тухай конвенцод заасны дагуу хөлөг онгоцны байршил тогтоох төхөөрөмж нь өөрийн байршлыг өдөрт 4-өөс багагүй удаа автоматаар үйлчилгээ үзүүлэгчид мэдээлнэ.

3.2. Хөлөг онгоцны байршлын мэдээллийг Үйлчилгээ үзүүлэгчид дамжуулснаас хойш 15 минутын дотор Захиргаанд мэдээлнэ.

3.3. Хөлөг онгоцны байршил тогтоох төхөөрөмж нь дараах мэдээллийг автоматаар дамжуулна.

3.3.1. хөлөг онгоцны нэр, төрөл, ОУДБ-ын дугаар,

3.3.2. хөлөг онгоцны байрлал, уртраг ба өргөрөг,

3.3.3. мэдээлэл дамжуулсан огноо, хугацаа.

#### **Дөрөв. Мэдээлэл дамжуулах давтамжийг өөрчлөх**

4.1. Хөлөг онгоц нь далайн аяллаа түр зогсоож боомтод засвар үйлчилгээнд орох тохиолдолд хөлөг онгоцны ахмад Захиргаанаас зөвшөөрөл авсны үндсэн дээр хөлөг онгоцны байршлын мэдээлэл дамжуулах давтамжийг өдөрт нэг удаа болгож өөрчлөх эсхүл төхөөрөмжийг түр хугацаагаар унтрааж болно.

4.2. Хөлөг онгоцны ахмад нь мэдээлэл дамжуулах давтамжийг өөрчилсөн огноо, цагийг тэмдэглэж, Захиргаанд мэдэгдэнэ.

#### **Тав. Захиргааны эрх, үүрэг**

5.1. Захиргаа нь системийг хэрэглэх хэрэглэгчийн нэrsийг үйлчилгээ үзүүлэгчид хүргүүлнэ.

5.2. Захиргаа нь хөлөг онгоцыг алсын зайнаас хянахын тулд дараах мэдээллүүдийг үйлчилгээ үзүүлэгчид хүргүүлнэ.

5.2.1. хөлөг онгоцны нэр,

5.2.2. ОУДБ-ын дугаар,

5.2.3. дуудлагын дугаар,

5.2.4. хиймэл дагуулын холбооны дугаар.

5.3. Захиргаа нь алсын зайнаас хянах хөлөг онгоцонд системийн тохиргоо, туршилт хийлгүүлэхээр хөлөг онгоцны эзэмшигч болон үйлчилгээ үзүүлэгчид мэдэгдэнэ.

5.4. Захиргаа нь хөлөг онгоцны дараах мэдээллийг системд оруулахаар үйлчилгээ үзүүлэгчид цахимаар хүргүүлнэ.

5.4.1. хөлөг онгоцны үндсэн мэдээлэл,

5.4.2. хөлөг онгоцыг бүртгэлээс хассан тухай,

5.4.3 хөлөг онгоцны бүтэц, тоног төхөөрөмж, тохируулга, зохион байгуулалт болон материалд өөрчлөлт орсон талаарх мэдээлэл.

#### **Зургаа. Үйлчилгээ үзүүлэгчид тавигдах шаардлага**

6.1. Үйлчилгээ үзүүлэгч нь олон улсын гэрээ, конвенц, хууль тогтоомж, дүрэм, журам, стандартад нийцүүлэн мэргэжлийн өндөр түвшинд үйлчилгээ үзүүлнэ.

6.2. Үйлчилгээ үзүүлэгч нь дараах шаардлагыг хангасан байна.

6.2.1. ОУДБ-аас хүлээн зөвшөөрсөн байх,

6.2.2. Олон Улсын Хөдөлгөөнт Хиймэл Дагуулын Байгууллагын аудитад жил бүр хамрагдаж, аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах,

6.2.3. системд шаардлагатай хөгжүүлэлт, тохиргоо, туршилтыг олон улсын шаардлагад нийцүүлэн гүйцэтгэх,

6.2.4. мэдээллийн системийн хэвийн үйл ажиллагааг хангахуйц чадамжтай байх,

6.2.5. шуурхай байдлын үед холбоо тогтоох боломжтой нөхцлийг бүрдүүлсэн байх.

6.3. Үйлчилгээ үзүүлэгчийн эдлэх эрх, хүлээх үүргийг Захиргаатай байгуулсан гэрээгээр зохицуулна.

#### **Долоо. Бусад**

7.1. Энэхүү журмыг зөрчсөн хувь хүн, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

---оОо---